

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН 2018 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

АГУУЛГА

1	Аудитын гэрчилгээ.....	2
2	Аудитын тайлан	4
2.1	Оршил	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	7
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	8
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.11	Шилэн дансны мэдээлэл	8
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	9
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
3	Менежментийн захидал.....	10
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	11
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	11
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	13
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	15
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	17
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	18
5	Аудитын явцад илэрсэн алдаа зөрчлийн жагсаалт.....	20

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

ЮНЕСКО-ИЙН МОНГОЛЫН
ҮНДЭСНИЙ КОМИССЫН ЕРӨНХИЙ
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА С.УЯНГА
ТАНАА

2019.02.28 № 06/353
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 АУДИТЫН ТАЙЛАН

2.1 ОРШИЛ

Юнеско-ийн Монголын үндэсний комиссын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Юнеско-ийн Монголын үндэсний комиссын Ерөнхий нарийн бичгийн дарга С.Уянга Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Юнеско-ийн Монголын үндэсний комиссын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Юнеско-ийн Монголын үндэсний комиссын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 1 дүгээр сарын 3-наас 2019 оны 2 дугаар сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 2 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, “Б энд С аудит” ХХК-ын аудитор Ц.Чанцалдиймаа хариуцаж хэрэгжүүлэв.

Юнеско-ийн Монголын үндэсний комисс 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Б энд С аудит” ХХК-нд 2019 оны 1 дүгээр сарын 23-нд ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Юнеско-ийн Монголын үндэсний комиссын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго: Комиссын үндсэн зорилго нь үндэсний хууль тогтоомж, ЮНЕСКО-гийн дүрэм, олон улсын нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн зарчим хэм хэмжээг удирдлага болгон Монгол, Юнеско-ийн хамтын ажиллагааг хөгжүүлэх явдал юм.

Комисс нь үйл ажиллагаанд монголын эрх ашгийг эрхэмлэн улс орны эдийн засаг, нийгмийн салбарт тавигдаж байгаа зорилтыг хэрэгжүүлэхэд Юнеско-ийн үйл ажиллагаанд Монгол улсын идэвхитэй оролцоог хангаж боловсрол, шинжлэх ухаан, соёл, мэдээллийн салбарт түүний бүсийн төвүүд, үндэсний байгууллагатай хамтын ажиллагааг зохицуулна.

Монгол орны түүх соёлын өв дурсгалт зүйл, байгалийн өвөрмөц тогтоц, үнэт ховор баялаг, нөөцийг хайрлан арвижуулах, нөхөн сэргээх талаар гишүүн орнуудтай нягт хамтран ажиллах чиглэлийг удирдлага болгоно.

Монголын нүүдэлчдын соёл иргэншил, уламжлалт соёл, боловсрол, шинэжлэх ухааны талаар гадаад ертөнцөд таниулах, эдгээр салбарын хөгжлийг хүн төрөлхтний нийтлэг ололт амжилт, өөрийн орны өвөрмөц онцлогыг харгалзан урагшлуулалхад Юнеско түүний системтэй тогтоосон хэлхээ холбоог оновчтой ашиглахыг чухалчилна.

Дэлхий нийтийн боловсрол, шинжлэх ухаан, соёл, мэдээллийг хөгжүүлэхэд чиглэсэн бүхийл үйл ажиллагааг идэвхитэй дэмжин улс түмний ойлголцол итгэлцлийг нэмэгдүүлэхэд тус төхөм үзүүлнэ.

Мөн Юнеско-ийн шугамаар Монгол улсын хэмжээнд хэрэгжиж байгаа хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрийг Монгол улсын нэрийн өмнөөс хариуцаж гүйцэтгэдэг. гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл: Юнеско-ийн Монголын үндэсний комиссын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Боловсрол

- Соёл
- Шинжлэх ухаан
- Мэдээлэл харилцаа холбоо

Юнеско-ийн Монголын үндэсний комиссын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Юнеско-ийн Монголын үндэсний комиссын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Захиргааны ерөнхий тухай хууль
- Зөрчлийн тухай хууль
- Татварын багц хууль
- Монгол Улс Юнеско-ийн хооронд харилцан ойлголцох санамж бичиг

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Юнеско-ийн Монголын үндэсний комиссын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Юнеско-ийн Монголын үндэсний комиссын санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн санхүүгийн тооцоолох Acolous програм хангамж ашигладаг байна.

Юнеско-ийн Монголын үндэсний комиссын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “бага” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт “үр нөлөөгүй” гэж үзлээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Юнеско-ийн Монголын үндэсний комиссын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 13 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 3 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Нийт орлогын 1 хувиар сонгов.

Нийт орлогыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь эрсдэл өндөр байх магадлалтай гэж үзсэнтэй холбоотой юм.

Юнеско-ийн Монголын үндэсний комиссын 2018 оны нийт орлого 571,166.7 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 5,711.67 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь санхүүгийн тайланд нөлөөлөх эрсдэл бага байгаатай холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 3 чиглэлээр аудитын 13 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 1 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 12 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэсэн.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй
асуудлыг ангилсан байдал

(мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	1	420.3	ХХОАТ-ын тухай хуулийг мөрдөж ажиллаагүй
	Дүн	1	420.3	

2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудал гараагүй болно.

2.9 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц чухал асуудал үгүй болно.

2.10 ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Юнеско-ийн Монголын үндэсний комиссын чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 22 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 146,521.0 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 143,279.6 мянган төгрөг буюу 97.8 хувьтай байгаа нь батлагдсан орон тооноос 2 орон тоог хэмнэж үүнийг дагалдах цалин хөлс хэмнэснээс шалтгаалжээ.

2.11 Шилэн дансны мэдээлэл

Юнеско-ийн Монголын үндэсний комисс нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Юнеско-ийн Монголын үндэсний комиссын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Юнеско-ийн Монголын үндэсний комиссын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Юнеско-ийн Монголын үндэсний комиссын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Юнеско-ийн Монголын үндэсний комисс нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 БАЛАНСЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

3.1.1 Илрүүлэлт

ХХОАТ-ын тухай хуулийн шинэчлэлийг мөрдөж ажиллаагүйгээс 420.3 мянган төгрөгийг илүү суутгасан нь ХХОАТ-ын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх заалттай нийцэхгүй байна.

Энэ нь үнэн зөв байх, оршин байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.1.2 Эрсдэл

Татвар, болон санхүүгийн тайлангийн үлдэгдэл буруу илэрхийлэгдэх, ажилтан албан хаагчдын цалин хөлс илүү дутуу бодогдох

3.1.3 Өгсөн зөвлөмж

2019 оны 1 дүгээр улиралд багтаан залруулга хийх

3.1.4 Байгууллагаас ирсэн хариу тайлбар

2019 оны 2 дугаар сарын цалин дээр залруулгыг хийж зөрчлийг арилгасан.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 6 дугаар сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

4.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2018 оны 12 сарын 31-ны өдрөөр дуусгавар болсон тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>75,738,969.86</u>	<u>49,412,859.54</u>
33	АВЛАГА	46,075,774.16	40,035,558.84
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага		2,000.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	46,075,774.16	38,180,514.24
335	Бусад авлага	-	1,853,044.60
3351	Байгууллагаас авах авлага		1,841,400.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага		11,644.60
34	УРЬДЧИЛГАА	19,632,000.00	-
34600	Урьдчилж гарсан зардал	19,632,000.00	
35	БАРАА МАТЕРИАЛ	10,031,195.70	9,377,300.70
354	Хангамжийн материал	10,031,195.70	9,377,300.70
35410	Бичиг хэргийн материал	469,180.00	495,186.00
35440	Түлш, шатах тослох материал	513,320.03	529,071.03
35470	Бусад хангамжийн материал	9,048,695.67	8,353,043.67
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>35,677,080.58</u>	<u>17,643,824.76</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	35,677,080.58	17,643,824.76
392	Биет хөрөнгө	35,677,080.58	17,643,824.76
39203	Авто-тээврийн хэрэгсэл	55,000,000.00	55,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	34,375,000.05	45,375,000.09
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	33,541,380.00	33,541,380.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	27,311,103.33	29,133,303.33
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	19,575,147.00	19,575,147.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	13,856,730.01	18,606,452.88
39214	Бусад үндсэн хөрөнгө	4,910,821.00	4,910,821.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	2,076,934.03	2,536,266.94
39217	Ном	269,500.00	267,500.00
393	Биет бус хөрөнгө	-	-
39301	Програм хангамж	770,000.00	770,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	770,000.00	770,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>111,416,050.44</u>	<u>67,056,684.30</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>47,698,276.90</u>	<u>40,385,409.15</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	47,698,276.90	40,385,409.15
413	Өглөг	47,698,276.90	40,385,409.15
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	1,622,502.74	
4136	Бусад өглөг	46,075,774.16	40,385,409.15
41361	Байгууллагад төлөх өглөг	46,075,774.16	38,180,514.24
41362	Хувь хүмүүст төлөх өглөг		918,178.89
41363	Татварын өглөг /ТӨҮГ/		33,802.25
41364	НДШ - ийн өглөг /ТӨҮГ/		1,252,913.77
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>63,717,773.54</u>	<u>26,671,275.15</u>

Юнеско-ийн Монголын үндэсний комиссын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

51	Засгийн газрын хувь оролцоо	63,717,773.54	26,671,275.15
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	78,398,015.00	78,398,015.00
512	Хуримтлагдсан үр дүн	-14,680,241.46	-51,726,739.85
51210	Өмнөх үеийн үр дүн	-34,449,702.76	-14,680,241.46
51220	Тайлант үеийн үр дүн	19,769,461.30	-37,046,498.39
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>111,416,050.44</u>	<u>67,056,684.30</u>

4.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2018 оны 12 сарын 31-ны өдрөөр дуусгавар болсон тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	535,044,884.65	571,166,713.30
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	412,937,884.65	424,645,713.30
120	Нийтлэг татварын бус орлого	412,937,884.65	424,645,713.30
120009	Бусад орлого	412,937,884.65	424,645,713.30
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	122,107,000.00	146,521,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	122,107,000.00	146,521,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	122,107,000.00	146,521,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	515,275,432.29	608,213,211.69
21	УРСГАЛ ЗАРДАЛ	513,930,015.80	608,213,211.69
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	510,758,772.99	604,971,841.81
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	87,482,502.34	88,962,045.55
210101	Үндсэн цалин	65,331,702.34	65,760,231.12
210102	Нэмэгдэл	10,494,100.00	11,820,271.57
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,656,700.00	11,381,542.86
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9,623,000.00	10,536,095.51
210201	Тэтгэврийн даатгал	6,123,800.00	6,679,092.01
210202	Тэтгэмжийн даатгал	874,800.00	1,022,050.34
210203	ҮОМШӨ-ний даатгал	817,935.07	866,587.93
210204	Ажилгүйдлийн даатгал	175,700.00	157,795.40
210205	Эрүүл мэндийн даатгал	1,630,764.93	1,810,569.83
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,200,602.74	8,955,597.26
210304	Байрны түрээс	12,200,602.74	8,955,597.26
2104	Хангамж, бараа материалын зардал	5,274,979.00	5,378,262.40
210401	Бичиг хэрэг	727,760.00	1,060,990.00
210402	Тээвэр, шатахуун	3,184,019.00	3,283,819.48
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,363,200.00	1,033,452.92
2107	Томилолт, зочны зардал	752,100.00	437,873.99
210702	Дотоод албан томилолт	246,700.00	246,700.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	505,400.00	191,173.99
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,415,524.66	9,516,242.61
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,098,724.66	8,199,442.61
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	1,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	198,000.00	198,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	99,000.00	99,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	19,800.00	19,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	391,010,064.25	481,185,724.49
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	378,657,005.68	463,154,468.67
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	12,353,058.57	18,031,255.82

Юнеско-ийн Монголын үндэсний комиссын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,171,242.81	3,241,369.88
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,700,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,700,000.00	
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	471,242.81	3,241,369.88
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	471,242.81	3,241,369.88
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,345,416.49	-
2200	Дотоод эх үүсвэрээр	1,345,416.49	-
225101	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз) /ТӨҮГ/	1,345,416.49	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>19,769,452.36</u>	<u>-37,046,498.39</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>19,769,452.36</u>	<u>-37,046,498.39</u>

4.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2018 оны 12 сарын 31-ны өдрөөр дуусгавар болсон тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>581,120,649.87</u>	<u>609,347,227.54</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	581,120,649.87	609,347,227.54
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	122,107,000.00	146,521,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	122,107,000.00	146,521,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	459,013,649.87	462,826,227.54
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	429,585,275.50	462,680,784.66
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	29,428,374.37	145,442.88
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>581,120,859.71</u>	<u>609,347,227.54</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	581,120,859.71	609,347,227.54
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	531,873,842.74	567,925,343.42
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	87,482,502.37	87,686,146.12
210101	Үндсэн цалин	65,331,702.37	64,484,331.69
210102	Нэмэгдэл	10,494,100.00	11,820,271.57
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,656,700.00	11,381,542.86
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9,623,000.00	10,536,095.51
210201	Тэтгэврийн даатгал	6,123,800.00	7,221,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	874,800.00	902,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	817,935.07	722,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	175,700.00	131,561.79
210205	Эрүүл мэндийн даатгал	1,630,764.93	1,557,833.72
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,578,100.00	10,578,100.00
210304	Байрны түрээс	10,578,100.00	10,578,100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,469,340.00	5,446,642.26
210401	Бичиг хэрэг	872,940.00	870,020.00
210402	Тээвэр, шатахуун	3,233,200.00	3,233,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,363,200.00	1,343,422.26
2107	Томилолт, зочны зардал	752,100.00	751,903.99
210702	Дотоод албан томилолт	246,700.00	246,700.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	505,400.00	505,203.99
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,006,224.66	23,277,827.52
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,689,424.66	21,961,027.52
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	1,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	198,000.00	198,000.00

Юнеско-ийн Монголын үндэсний комиссын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210804	Тээврийн хэрэгслийн татвар	99,000.00	99,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	19,800.00	19,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	412,962,575.71	429,648,628.02
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	412,962,575.71	429,648,628.02
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	49,247,016.97	41,421,884.12
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,700,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,700,000.00	
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	46,547,016.97	41,421,884.12
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	46,547,016.97	41,421,884.12
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>-209.84</u>	≡
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
14	Бусад эх үүсвэр	8.94	-
145006	Гадаадын санхүүгийн зах зээлээс санхүүжих	8.94	
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>8.94</u>	≡
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-200.90	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	200.90	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

4.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2018 оны 12 сарын 31-ны өдрөөр дуусгавар болсон тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2017 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	78,398,015.00	-34,449,702.76	43,948,312.24
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	78,398,015.00	-34,449,702.76	43,948,312.24
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт			0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт			0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз			0.00
C07	Тайлант үеийн үр дүн		19,769,461.30	19,769,461.30
C08	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	78,398,015.00	-14,680,241.46	63,717,773.54
D01	2018 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	78,398,015.00	5,089,219.84	63,717,773.54
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	78,398,015.00	-14,680,241.46	63,717,773.54
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт			0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт			0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз			0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү			0.00
D08	Тайлант үеийн үр дүн		-37,046,498.39	-37,046,498.39
D09	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	78,398,015.00	-51,726,739.85	26,671,275.15

4.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2018 оны 12 сарын 31-ны өдрөөр дуусгавар болсон тайлан

/Төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	146,521,000.0	143,279,630.12	3,241,369.88	97.79
21	УРСГАЛ ЗАРДАЛ	146,521,000.0	143,279,630.12	3,241,369.88	97.79
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	146,521,000.0	143,279,630.12	3,241,369.88	97.79
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	90,271,800.00	87,686,146.12	2,585,653.88	97.14
210101	Үндсэн цалин	66,121,000.00	64,484,331.69	1,636,668.31	97.52
210102	Нэмэгдэл	12,494,100.00	11,820,271.57	673,828.43	94.61
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,656,700.00	11,381,542.86	275,157.14	97.64
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,832,600.00	10,536,095.51	296,504.49	97.26
210201	Тэтгэврийн даатгал	7,221,800.00	7,221,800.00	-	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	902,700.00	902,700.00	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	722,200.00	722,200.00	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	180,500.00	131,561.79	48,938.21	72.89
210205	Эрүүл мэндийн даатгал	1,805,400.00	1,557,833.72	247,566.28	86.29
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,578,100.00	10,578,100.00	-	100.0
210304	Байрны түрээс	10,578,100.00	10,578,100.00	-	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	5,505,200.00	5,446,642.26	58,557.74	98.94
210401	Бичиг хэрэг	908,800.00	870,020.00	38,780.00	95.73
210402	Тээвэр, шатахуун	3,233,200.00	3,233,200.00	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,363,200.00	1,343,422.26	19,777.74	98.55
2107	Томилолт, зочны зардал	752,100.00	751,903.99	196.01	99.97

Юнеско-ийн Монголын үндэсний комиссын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210702	Дотоод албан томилолт	246,700.00	246,700.00	-	100.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	505,400.00	505,203.99	196.01	99.96
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	23,556,500.00	23,277,827.52	278,672.48	98.82
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	22,150,700.00	21,961,027.52	189,672.48	99.14
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,089,000.00	1,000,000.00	89,000.00	91.83
210803	Даатгалын үйлчилгээ	198,000.00	198,000.00	-	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	99,000.00	99,000.00	-	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	19,800.00	19,800.00	-	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,024,700.00	5,002,914.72	21,785.28	99.57
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,024,700.00	5,002,914.72	21,785.28	99.57
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	146,521,000.0	143,279,630.12	3,241,369.88	97.79
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	146,521,000.0	143,279,630.12	3,241,369.88	97.79
131001	Улсын төсвөөс санхүүжих	146,521,000.0	143,279,630.12	3,241,369.88	97.79
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	19.00	19.00	-	100.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	9.00	9.00	-	100.0
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	6.00	6.00	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	2.00	2.00	-	100.0

5 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Юнеско-ийн Монголын үндэсний комиссын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн	Аудитын код:
2019.02.20			САГ-2019/262/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Юнеско-ийн Монголын үндэсний комисс		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	Тайлант оны эцэст хуулийн шинэчлэлийг мөрдөж ажиллаагүйгээс ХХОАТ-ын хөнгөлөлтийг 0.4 мянган төгрөгөөр дутуу тооцсон байна.	0.4	Зөвлөмж өгөх	Ерөнхий нягтлан бодогч	А.Алтантуяа
	Дүн	0.4			

